

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр, Баасан гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-4

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 5-8

---

**1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай  
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл  
болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын  
төслийг /Засгийн газар 2025.01.22-ны өдөр өргөн  
мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/** 5-8

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны тоөч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 28 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: Т.Доржханд, Ц.Сандаг-Очир, Л.Мөнхбаатар;  
Чөлөөтэй: С.Амарсайхан, С.Бямбацогт, Л.Оюун-Эрдэнэ, Н.Номтойбаяр,  
Н.Учрал, О.Цогтгэрэл;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баярмаа, Г.Уянгахишиг, Л.Гантөмөр.*

***Нэг.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын референт Д.Нямдэлгэр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Шинэ Зуунмод хотуудын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул байлцав.

***Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

***Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын***

*тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл, заалт бүрээр хэлэлцэв.*

**1.Шинэ Зуунмодын хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**4.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**5.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**6.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**7.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**8.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

## 9.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл, заалт бүрээр хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13
46.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.	

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл санал хураалтыг гар өргөж явуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.**

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.	

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналаар хураасан санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 11 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 09 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
11 цаг 28 минут.

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хороонд хуралдаанд оролцсон гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн. Баярмагнай Баярбаатар гишүүн ирсэн. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн. Энхбатын Болормаа гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Пүрэвдорж гишүүн ирсэн. Амарбаясгалан гишүүн ирсэн.

Ингээд Байнгын хорооны олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудал байгаа.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Засгийн газар 2025 оны 1 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Саналтай гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийг нь танилцуулъя. Ц.Цэрэндорж Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, Д.Нямдэлгэр Загсийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын референт, М.Үнэнбат Нийслэлийн Засаг дарагын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, М.Батбаяр Шинэ Зуунмод хотуудын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч гэсэн хүмүүс ирсэн байна.

Энэ чинь юу байгаа биз дээ танилцуулга? Байхгүй юу?

Хууль, тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Хууль, тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байхгүй юу? Үг хэлэх дэг байхгүй юм байна шүү.

Ингээд хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Шинэ Зуунмодын хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Алга байна.

6.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Алга байна.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Алга байна.

8.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Алга байна.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Алга байна.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгүүдийг хийж дууслаа.

Баярбаатар гишүүн.

**Б.Баярбаатар:** Өнөөдөр чуулганаар хэлэлцэх эсэх нь бол шийдэгдээд олонхын саналаа авчихсан. Одоо Байнгын хороо анхны хэлэлцүүлгээ хийлээ.

Зарчмын зөрүүтэй санал гарсангүй. Дагасан бүх тогтоолын төслүүд дэмжигдээд явж байгаа учраас Их Хурлын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлгээр батлах горимын саналыг оруулж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураана. Санал хурааж шийднэ.

Баярбаатар гишүүний гаргасан зарчмын саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт.

Минийх болсонгүй. Ингээд улаан гарчихлаа. Алтангэрэл гишүүн.

**О.Алтангэрэл:** Энэ төхөөрөмж дийлэнх тохиолдолд гацаад байгаа учраас саналыг илээр хураах санал гаргаж байна. Горимын санал гар өргөж саналыг илээр хураая гэсэн санал гаргаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Алтангэрэл гишүүний, сайдын гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

13-аас 7 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд түрүүний явуулсан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

13-аас 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд санал хүчингүй болсон тул Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

13-аас 9 үү? 9 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар гишүүн танилцуулъя.

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье.

Баярлалаа гишүүд.

11.37 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

